



УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ 500 ТӨГРӨГНИЙ ДЭВСГЭРТИЙГ ХУУЛЬ ЁСНЫ ТӨЛБӨРИЙН ХЭРЭГСЭЛД ТООЦОХ, ГҮЙЛГЭЭНД ГАРГАХЫГ ЗӨВШӨӨРӨХ ТУХАЙ 1993 оны 5 дугаар сарын 20-ны өдөр Улаанбаатар хот Дугаар 38 Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь: 1."Мөнгөн тэмдэгтийн хэв загварыг батлах тухай" Улсын Бага Хурлын 1992 оны 5 дугаар сарын 19-ний өдрийн 32 дугаар тогтоолын дагуу хэвлэгдсэн "500 төгрөг"-ийн дэвсгэртийг Монгол Улсын хууль ёсны төлбөрийн хэрэгсэлд тооцсугай. 2.Бэлэн мөнгөний гүйлгээний байдал, хэрэгцээг харгалзан Монгол улсын Банкны хуулийн 12 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасныг үндэслэн "500 төгрөг"-ийн дэвсгэртийг гүйлгээнд гаргахыг Монголбанк (Д.Моломжамц)-д зөвшөөрсүгэй. ДАРГА Н.БАГАБАНДИ ТАМГЫН ГАЗРЫН ЕРӨНХИЙ НАРИЙН БИЧГИЙН ДАРГА Н.РИНЧИНДОРЖ